



ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

**Аудитын нэр: ЕРӨӨ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

Аудитад хамрагдсан жил: 2024

**АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА: СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА**

АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: “ЕРӨӨ СУМЫН ТТЗ”

АУДИТ ХИЙГДСЭН ОБЪЕКТ: ЕРӨӨ СУМ

АУДИТЫН ТӨРӨЛ: ДОТООД АУДИТ

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА: 2024.10.28-2024.11.15

АУДИТАД ХАМРАГДСАН ХУГАЦАА: 2024 оны 3 дугаар улирал

Тайланг бэлтгэсэн:

**Дотоод аудитын нэгжийн
удирдлагын дарга**

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
дэргэдэх Санхүүгийн хяналт,
дотоод аудитын албаны дарга,
СХШУАБ Т.Одсүрэн

Аудитын багийн гишүүн:

Дотоод аудитор Х.Батбаатар,

Огноо: 2024 оны 11 дүгээр
сарын 15 өдөр

Сүхбаатар сумын 2 дугаар баг.
Нутгийн удирдлагын II байр
sankhuu_audit_se@yahoo.com

1. ТАНИЛЦУУЛГА

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ,

2.1. Аудитын зорилго

2.2 Аудитын цар хүрээ

2.3. Аудитын арга аргачлал, хязгаарлалт

3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

3.1 Засаглалын талаар

3.2 Эрсдэлийн удирдлагын талаар

3.3 Дотоод хяналтын талаар

4. АУДИТЫН ҮР ДҮН

4.1 Илэрсэн асуудлууд

5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. ТАНИЛЦУУЛГА

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, “Дүрэм батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Дотоод аудитын хорооны 2024 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг аймгийн Засаг дарга бөгөөд Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 12 дугаар удирдамжийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ.

Дотоод аудитыг Засгийн газрын 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийг тус тус үндэслэн санхүүгийн хяналт шалгалт, эрх зүйн нийцлийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ба 2024 оны 3 дугаар улирлын үйл явцыг хамруулан, дахин тооцоолох, тулган шалгах хяналтын горимыг ашиглах, холбогдох ажилтнуудтай ярилцах, дотоод хяналтын орчныг судлах, үнэлэх, ажил гүйлгээг батлах, хянах, бүртгэх, тайлагнах процессын эрсдэлийг үнэлэх, мөрдвөл зохих хууль тогтоомжийн зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн байдлыг бодитоор илэрхийлж тогтоох, зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж байгаа байдлыг шалгуур үзүүлэлтээр тодорхойлж ажиллав.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго:

Ерөө сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Ерөө сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн удирдлага зохион байгуулалтын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг үнэлэх;

Аудитаар тус газрын 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг хамруулна. Үүнд:

- *Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлагын үйл явцыг үнэлэх;*
- *Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль, тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт.*
- *Төсвийн орлогын бүрдүүлэлт, санхүүжилт, хуваарилалт, үр дүн*
- *Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт үйл ажиллагааны үр дүн*
- *Хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр дүн*
- *Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ*

- худалдан авах тухай хууль тогтоомжийн хэрэгжилт
- Өр авлагын барагдуулалт, үүссэн өр авлагыг данс бүртгэлд тусгасан эсэх;
 - Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналтын үр нөлөө
 - Төрийн аудитын байгууллагаас 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил дутагдлын арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал

Аудитын хамрах хүрээний хязгаарлалт:

Ерөө сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны үйл ажиллагааны хамрах хүрээнд хязгаарлалт байхгүй болно.

2.3 Аудитын арга, аргачлал

Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон улсын стандарт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Монгол улсын сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар батлагдсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын дагуу үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэн албан тушаалтнаас асуулга тодруулга авах, нотлох зүйлсийг нягтлах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх горимуудыг ашиглав.

2.4. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, журам, дүрэм, зааврыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Авлигын эсрэг хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам
- Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам
- УСНББОУС болон бусад стандартууд
- Төрийн сангийн төлбөр тооцооны журам
- Бусад хууль, эрх зүйн актууд

2.5 Аудитын хугацаа, бүрэлдэхүүн

Дотоод аудитыг 2024 оны 11 дугаар сарын 22-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны

дарга (Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч) Т.Одсүрэн хянан удирдаж, дотоод аудитор Х.Батбаатар гүйцэтгэв.

3. Байгууллагын сайн туршлага

Ерөө сумын ЗДТГ, Бугант тосгоны захирагчийн алба нь Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын бодлого шийдвэр, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийн зорилтын хэрэгжилтийг зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавин, иргэдэд төрийн үйлчилгээг ил тод, түргэн шуурхай, нээлттэй, тэгш хүртээмжтэй хүргэж ирсний үр дүнд ЗДТГ нь 2011, 2014, 2011, 2022 онуудад аймгийн “Тэргүүний сум”, 2023 онд төсвийн бүсийн “Шилдэг сум” Бугант тосгоны захирагчийн алба нь 2022, 2023 онуудад аймгийн тэргүүний тосгоноор шалгарч байсан бөгөөд сумдаас аймагт төвлөрүүлэх орлого 2022 оноос эхлэн аймагт орлого төвлөрүүлж эхэлсэн бөгөөд 2022 онд 1,398.5 мянган төгрөг 2023 онд 2,787.6 мянган, 2024 онд 1,413.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Улсын болон аймаг сум, болон аж ахуйн нэгж байгууллагуудын хамтын ажиллагаа, нийгмийн хариуцлагын хүрээнд уул уурхайн эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, хөрөнгө оруулалтын ажлуудыг өөрийн сум, тосгонд татаж чадсан нь тодорхой үр дүнд хүрээнд байна.

3.1 Засаглалын талаар

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын удирдлагын баг нь орон нутгийн 9 дэх удаагийн сонгуулийн үр дүнгээр зохин байгуулсан ИТХ-ын анхдугаар хуралдаанаар Т.Болдыг ИТХ-ын даргаар томилж, Э.Одбаярыг Засаг даргаар нэр дэвшүүлэн аймгийн Засаг даргад уламжлах шийдвэрийг гаргаад байна. Бидний хяналт шалгалтад хамрагдах хугацаа нь өмнөх удирдлагын үеийн шийдвэр гаргалттай холбоотойг онцлон дурдах нь зүйтэй юм.

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын удирдлагын багийн удирдлагад сумын ИТХ-ын даргаар Э.Ариунбат нь 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс өнөөдрийг хүртэл, сумын Засаг дарга Б.Сэргэлэн нь 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс өнөөдрийн хүртэл, Засаг даргын орлогч Л.Болормаа 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөс өнөөдрийн хүртэл, Тавин 1 дүгээр багийн Засаг даргаар Б.Батбаатар 2022 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс өнөөдрийг хүртэл, Буурагчин 2 дугаар багийн Засаг даргаар Э.Эрдэнэ-Очир 2022 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс 3 дугаар багийн /Бугант тосгоны захирагч/-аар Д.Эрдэнэбулган 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өнөөдрийг хүртэл, сумын Засаг даргын Тамгын газрын дарга С.Цэвэлмаа 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс өнөөдрийг хүртэл, Сумын төсвийн ерөнхий нягтлан бодогч А.Төгсжаргал 2007 оны 10 дугаар сарын 18-ний өдрөөс өнөөдрийг хүртэл тус тус ажиллаж байна.

Сумын Засаг дарга Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын бодлого шийдвэр, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийн зорилтын хэрэгжилтийг зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавин, иргэдэд төрийн үйлчилгээг ил тод, түргэн шуурхай, нээлттэй, тэгш хүртээмжтэй хүргэхэд гол ажлуудыг шийдвэрлэсэн байна.

Аймгийн Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсээс Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хэрэгжилтийг ханган хагас бүтэн жилээр бүх шатны захиргааны байгууллага нь өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.

3.2 Эрсдэлийн удирдлагын талаар

Тус сум нь эрсдэлийн удирдлагын бодлого, журам боловсруулаагүй, тусдаа хариуцсан ажилтан нэгж байгуулаагүй, одоогоор эрсдэлийн бүртгэл байхгүй. Эрсдэлийн удирдлагаар хангах ажлын төлөвлөгөө гаргаж батлуулаагүй, Байгууллагын эрсдэлийн үйл явцыг үнэлэхэд хүлээн зөвшөөрөх эрсдэл, эрсдэлийн үнэлгээ, түүний талаар нэгдсэн ойлголт чиг хандлага, эрсдэлийн мэдээллийг ашиглах ашиглах зэрэг

Удирдлагын “ёс зүйтэй байдлыг дэмжин урамшуулах байдал”, ёс зүйгүй үйлдлийн эсрэг хандах хандлага, авах арга хэмжээ буруу, удирдлага шаардлага тавьсан ч үе шатны хяналтыг дутуу орхигдуулснаас хэрэгжилт нь хангалтгүй.

Байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвшлийг тодорхойлоход эрсдэлийн соёл, эрсдэлийн засаглал, эрсдэлийн үйл явц эхлэлийн буюу 2-р түвшинд байна.

3.3 Дотоод хяналтын системийн талаар

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг Зохион байгуулах нийтлэг журам”-ын 1.5. Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө. 3.1. Энэхүү журмын 1.3-т заасан “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-д өөрөөр заагаагүй бол дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүргийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны асуудал хариуцсан нэгж, ажилтан (цаашид “дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан” гэх) гүйцэтгэнэ. гэж заасан байдаг.

Гэвч Төсвийн төвлөрүүлэн захирагчид шууд харьяалагдах дотоод хяналт хариуцсан ажилтны орон тоог одоог хүртэл батлуулаагүй гүйцэтгэх чиг үүрэг тодорхойгүй, дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмыг боловсруулж батлуулаагүйгээс дотоод хяналт сул байна.

Дотоод хяналтыг удирдамж, төлөвлөгөөг зөвхөн харьяа нэгжүүд өөрсдийн чиг үүргийн дагуу хийж байгаа нь нэгдсэн удирдлагын тогтолцоо бүрдээгүйг илэрхийлж байна.

4. АУДИТЫН ҮР ДҮН

<u>Илэрсэн асуудал 1</u>	Эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй Аюул эрсдэлийг тодорхой хэмжээнд ярилцдаг боловч баримтжуулаагүй.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их

<p>Бодит байдал: Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөхдөө учирч болох эрсдэлүүдийг авч бүртгэж түүнийг бууруулах талаар ярилцдаг боловч баримтжуулаагүй, үнэлгээ хийгдээгүй байна.</p>
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт-2120</p>
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Эрсдэлийн үнэлгээний ерөнхий ойлголт, ач холбогдол, үнэлгээ хийх арга аргачлалын талаар холбогдох албан тушаалтанд сургалт зохион байгуулдаггүй Эрсдэлийг зөвхөн шаардлагатай үед тодорхойлдог боловч бүрэн үнэлдэггүй.</p>
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</p> <ul style="list-style-type: none"> - Эрсдэлээ тодорхойлоогүй нөхцөлд байгууллага зорилгодоо хүрэхэд саад бэрхшээл тулгарах - Байгууллагын үнэ цэн буурна, төсөв санхүүгийн хүндрэл учирч хэвийн үйл ажиллагаа алдагдана
<p>Шийдвэр: Байгууллагын албан хаагчдад эрсдэлийн талаар ойлголт өгч, дотоод хяналтын нэгж хариуцсан ажиллагсдыг сургалтад үе шаттай хамруулж, чадавжуулах -Гүйцэтгэх удирдлага нь байгууллагын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэхдээ эрсдэлийн чиглэлээр ур чадвар бүхий ажилтан сонгон шалгаруулж авах -Байгууллагын эрсдэлийн түвшинг нэг шатлал ахиулан давтамжтай түвшинд шилжих зөвлөмж хүргүүлэх</p>

<u>Илэрсэн асуудал 2</u>	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх дотоод хяналтын төлөвлөгөө боловсруулаагүй байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
<p>Бодит байдал: Төсвийн төвлөрүүлэн захирагчид шууд харьяалагдах дотоод хяналт хариуцсан ажилтны орон тоог одоог хүртэл батлуулаагүй гүйцэтгэх чиг үүрэг тодорхойгүй, дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмыг боловсруулж батлуулаагүйгээс дотоод хяналт сул байна.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.4. дэх “Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, хэмжээ, зохион байгуулалтын бүтэц, харьяалагдах нэгж, объектын тоог харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана.”</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Дотоод хяналт хэрэгжүүлэг төлөвлөгөө боловсруулаагүй, дотоод хяналтын чиглэлээр ажил зохион байгуулаагүй үндсэн үйл ажиллагаанд болон гүйцэтгэх удирдлагад тавих хяналтын тогтолцоог журамлаагүй, хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулах хяналтуудыг орхигдуулсан.</p>	

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Удирдлагын хяналт, гүйцэтгэх удирдлагын уялдаа холбоо хангагдаагүй хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхой бусад нэгжийн дотоод хяналын үр нөлөө сул үнэлгээ дүгнэлт хангалтгүй байна.

Шийдвэр:

Өөрийн эрхлэх хүрээний асуудал хариуцсан байгууллагууд болон гүйцэтгэх удирдлага, болон үндсэн үйл ажиллагаанд хийх дотоод хяналт шалгалтын журмыг нэн яаралтай боловсруулах, дотоод хяналт хариуцсан ажилтантай болгож албан тушаалын тодорхойлолтод холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын заалтаар тусгаж өгөх. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.4. дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлэх

<u>Илэрсэн асуудал 3</u>	Төрийн цахим хур системд ЗДТГ-ын эзэмшиж, ашиглах эрх олгосон 63 газар байгаагаас санхүүгийн тайлан бүртгэлд бүртгэгдсэн 23 байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
Бодит байдал: Сумын Засаг даргын захирамжаар ЗДТГ-т газар эзэмшүүлэх эрх олгосон нийт 63 газраас улсын бүртгэлээс э-дугаар олгосон 32 газар байгаагаас ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн бүртгэлд 23 газар бүртгэлтэй бусад газрыг огт бүртгээгүй байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь “Төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2. бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны “Журам шинэчлэн батлах тухай” 271 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийн 3.8 дахь “Төрийн өмчит хуулийн этгээд нь газар эзэмших эрх шинээр авах саналаа тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан, холбогдох Газрын алба, сумын газрын даамалд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ. Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ”	
Асуудлын үндсэн шалтгаан: Засаг даргын дэргэдэх харьяа байгууллагуудын уялдаа холбоо хангалтгүй, албан хаагчдын ажлын хариуцлага сул хөрөнгийн бүртгэлд тавих хяналт хангалтгүйгээс бүртгэл тайланд тусгаагүй орхигдуулсан.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Санхүүгийн тайлан мэдээлэл үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт сулаас шамшигдуулах өөрийн эзэмшлийн газрыг улсын бүртгэлд бүртгүүлээгүйгээс ЗДТГ-ын эзэмшилд байгаа газар дээр давхар олголт үүснээс шалтгаалан газрын маргаан үүсэх нөхцөл байдал бүрдсэн.	

Шийдвэр: Сумын ЗДТГ-ын нэр дээрх үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгаагүй газрын үнэлгээг журмын дагуу үнэлж бүртгэлд авах, цаашид ашиглах шаардлагагүй бол хураан авч захирамжаар олгосон шийдвэрийг хүчингүй болгож цэгцлэх, цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэх.

<u>Илэрсэн асуудал 4</u>	Захиргааны актаар аливаа эрх олгох шийдвэр олгох эрх зүйн үндэслэлийг хууль тогтоомжоор эрх олгосон нарийвчлан зүйл заалтыг үндэслээгүй байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
Бодит байдал: Сумын Засаг даргын захиргааны шийдвэр гаргалтын эрх зүйн үндэслэл хэсэгт хууль тогтоомжоор эрх олгосон болон, захиргааны хэм хэмжээний актаар нарийвчилсан зүйл заалтыг үндэслэхгүй байгаа нь илт хууль бус шийдвэр гаргах эрсдэлийг үүсгэж байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/:	
Асуудлын үндсэн шалтгаан: ЗЕХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.3.Захиргааны актын хууль зүйн үндэслэлд захиргааны байгууллага захиргааны акт гаргах эрх олгогдсон хуулийн зүйл, заалтыг тодорхой заана. 45 дугаар зүйл.Захиргааны актын илэрхий алдааг засах 45.1.Захиргааны актын бичилт болон тооцооны алдаа, түүнтэй адилтгаж болохоор өөр бусад илэрхий алдааг захиргааны актын үндсэн зохицуулалт, утга, агуулгыг өөрчлөхгүйгээр захиргааны байгууллага өөрөө, эсхүл оролцогчийн хүсэлтээр засах эрхтэй бөгөөд уг засварыг оролцогчид мэдэгдэх үүрэгтэй. 47 дугаар зүйл.Захиргааны акт илт хууль бус болох 47.1.3.тухайн захиргааны байгууллага өөрийн чиг үүрэгт үл хамаарах асуудлаар захиргааны акт гаргасан; 47.1.6.захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй;	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Захиргааны ерөнхий хууль, захиргааны хэм хэмжээний акт зөрчигдөх	
Шийдвэр:	
<ul style="list-style-type: none"> ✓ Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч нарийвчилсан зохицуулалттай хуулийн заалт, болон хуулиар эрх олгосон захиргааны хэмж хэмжээний актын зүйл заалтыг үндэслэж байх. ✓ Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актаар зохицуулагдаагүй тохиолдолд захиргааны шийдвэр гаргахгүй байх. ✓ Захиргааны актад ерөнхий зохицуулалттай хуулийн заалтыг үндэслэхдээ зөвхөн эрх олгосон заалтыг үндэслэж шийдвэр гаргаж байх зөвлөмж хүргүүлэх. 	

<u>Илэрсэн асуудал 5</u>	Төсвийн төслийг үндэслэлтэй бодитоор төлөвлөж батлуулаагүй, ЗДТГ-ын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалт бүтэц орон тоог оновчтой хийгээгүйгээс гүйцэтгэлийг тайлагнахад холбогдох хууль тогтоомжтой нийцэхгүй байна.
---------------------------------	--

<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
Төсвийн төслийг төлөвлөж боловсруулж батлуулахдаа зардлын эдийн засгийн ангиллыг үнэн зөв төлөвлөөгүй, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн урсгал зардалд хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг тусгаж хэрэгжүүлсэн, орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөхдөө их засварын төсөл арга хэмжээг шинээр хэрэгжих төсөл арга хэмжээний жагсаалтад оруулж батлуулан хэрэгжүүлсэн.	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/:</p> <p>Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24."төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг", 14 дүгээр зүйлийн 14.2.12 дахь "эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 22.1.Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", 41.2.2 дахь "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Эдийн засгийн ангилал ашиглах заавар"</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг Хөдөлмөрийн тухай хууль, энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар тогтооно", 57 дугаар зүйлийн 57.17.Захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Төсвийн төслийг боловсруулах журам, аргачлалыг мөрдөөгүй, албан хаагчдын мэдлэг чадвар дутмагаас үндэслэлтэй бодитоор төлөвлөөгүйгээс Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардалд хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг тусгасан, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний их засварын ангилалд хамаарах төсөл арга хэмжээг, шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад оруулан баталсан, ЗДТГ, ИТХ-ын бүтэц орон тоо баталсан шийдвэр төрийн үйлчилгээний туслах албан тушаалын чиг үүргийг гэрээт ажилтнаар гүйцэтгүүлэхээр орон тоог баталсан боловч төсвийн төсөлд цалингийн зардлын тооцоолохдоо ТҮ- албан тушаалын ангилал зэрэглэлээр цалин хөлс нэмэгдлийн зардлыг тооцож, зардлын эдийн засгийн ангилалд гэрээгээр гүйцэтгүүлэх зардлын ангиллаар батлуулсан, Мөн цалингийн зардлын тооцоололд урамшуулал, хоолны зардлыг бодитоор тооцож төлөвлөөгүй атлаа гүйцэтгэлийг бодитоор тайлагнасан зэрэг зөрчил дутагдал илэрч байна.</p>	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг хэрэгжихгүй байх, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулахгүй байх, санхүүгийн тайлан мэдээлэл буруу илэрхийлэгдэх</p>	
<p>Шийдвэр:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төсвийн төсөл боловсруулах заавар аргачлалыг мөрдөн үнэн зөв төлөвлөж байх. ✓ Төсвийн сахилга бат, сахилга, хариуцлагыг сайжруулах ✓ Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтын ангиллыг зардлын зориулалтын дагуу төлөвлөх зөвлөмж хүргүүлэх. 	

<p><u>Илэрсэн асуудал 6</u></p>	<ol style="list-style-type: none"> 1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт үл хамаарах төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулсан. 2. тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын зардлыг Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн зардлаас төлөвлөж санхүүжүүлсэн.
<p><u>Асуудлын ангилал</u></p>	<p>Нөлөө дунд</p>
<p>Бодит байдал: ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтын 1.3.1 дахь Малын тоо толгойн албан татварын санхүүжилтээр “Багийн төв байр барих” 115,000.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээг малын тоо толгойн албан татварын санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөн батлуулсан.</p> <p>ЭМТ болон ЕБС нийт 62,730.8 мянган төгрөгийн тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжих хөрөнгийн зардлыг Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлсэн байна.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/:</p> <p>Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх”, 14 дүгээр зүйлийн 14.2.2 дахь “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 60 дугаар зүйлийн 60.2. дахь “малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ хийх, бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна.”, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаа батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.6.ОНХС-ийн хөрөнгийг зөвхөн дараах хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зарцуулах ба өөр бусад зорилгоор зарцуулахгүй: 4.6.1. Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгийг энэхүү журмын 4.5-д заасан зорилгоор;</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан: ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг журмын дагуу төлөвлөөгүй.</p>	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: ОНХС-ийн хөрөнгийг зориулалт бусаар үр ашиггүй зарцуулах</p>	
<p>Шийдвэр: Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасан чиг үүрэгт үл хамаарах төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулахгүй байх албан шаардлага хүргүүлэх</p>	

<p><u>Илэрсэн асуудал 7</u></p>	<p>Төсвийн орлогын бүрдүүлэлтийг эхний 3 дугаар улирлын байдлаар 80 хувьд хүрээгүй 8 төрлийн татварын орлого 3,540,942.6 мянган төгрөгөөр тасарснаас нийт төсвийн орлогын гүйцэтгэл 65.4 хувьтай байна.</p>
<p><u>Асуудлын ангилал</u></p>	<p>Нөлөө дунд</p>

<p>Бодит байдал: Төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь биелэлтийг тулган шалгахад Цалин түүнтэй адилтгах орлогын суутганы орлогын албан татвар 3,074,886.1 мянган төгрөгөөр буюу 43.1 хувиар, хөрөнгө борлуулсны орлого 11,151.8 мянган төгрөгөөр буюу 49.7 хувиар, Малын тоо толгойн албан татвар 57,641.2 мянган төгрөгөөр буюу 46 хувиар, дуудлага худалдааны сонгон шалгаруулалтын орлого 23,236.4 мянган төгрөгөөр буюу 48.4 хувиар, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 367,337.4 мянган төгрөгөөр буюу 25.3 хувиар, ус рашаан ашигласны төлбөр 228,010.0 мянган төгрөгөөр буюу 100 хувиар, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 1,346.9 мянган төгрөгөөр буюу 76.2 хувиар тус тус тасарсан байна.</p>
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/:Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 41.2.1.хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;</p>
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Төсвийн орлогын төлөвлөгөө тасрахад голлон нөлөөлсөн шалтгаан нь ХХОАТ-ыг аймгаас үндэслэлгүйгээр хэт өндрөөр баталсныг төсвийн тодотголоор 1,000,000 мянган төгрөгөөр бууруулсан, Мөн тус сумын татварын байцаагч хүүхэд асрах чөлөөтэй байгаа гэх үндэслэлээр орлогын төлөвлөгөөнүүд тасарсан, уул уурхайн томоохон ААНБ болох Болдтөмөр ерөө гол ХХК нь 6 дугаар сараас Цалин түүнтэй адилтгах орлогын суутганы орлогыг төвлөрүүлээгүйгээс 1,400,000 мянган төгрөгөөр тасарсантай холбоотой байна.</p>
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Төсвийн орлого бүрэн төвлөрөөгүйгээс шалтгаалан төлөвлөгдсөн зардлуудын санхүүжилтийн эх үүсвэр тасрах. Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмж буурах Хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхгүй байх</p>
<p>Шийдвэр: Төсвийн орлогын бүрдүүлэлтийг ангилал тус бүрээр төлөвлөгөөний дагуу бүрэн төвлөрүүлэх, ТЕЗ-д төсвийн орлогыг бүрдүүлэхтэй холбоотой татварын байцаагчийг орон нутагт томилон ажиллуулахад мэргэжлийн байгууллагатай нь хамтран дэмжлэг үзүүлэх чиглэлээр үр дүнтэй ажил зохион байгуулж ажиллах зөвлөмж хүргүүлэх.</p>

<p><u>Илэрсэн асуудал 8</u></p>	<p>Сумын ОНХО, ОНХС-ийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэл хангалтгүй байна.</p>
<p><u>Асуудлын ангилал</u></p>	<p>Нөлөө дунд</p>
<p>Бодит байдал: Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх шилжих болон шинээр хэрэгжүүлэх 3,477,790.8 мянган төгрөгийн 20 төсөл арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 2,011,413.4 мянган төгрөгийн 11 ТАХ, дутуу хэрэгжсэн 711,929.0 мянган төгрөгийн 2 ТАХ, огт хэрэгжээгүй 754,448.4 мянган төгрөгийн 7 төсөл арга хэмжээ байгаа бол ОНХО-аар хэрэгжүүлэх 2,975,690.2 мянган төгрөгийн 9 ТАХ-ээс бүрэн хэрэгжсэн 10,000.0 мянган төгрөгийн 1 ТАХ, дутуу хэрэгжсэн 1,893,328.2 мянган төгрөгийн 4 ТАХ, ог хэрэгжээгүй тендер шалгаруулалт, худалдан авах ажиллагаа дуусаагүй 1,072,360 мянган төгрөгийн 4 ТАХ байна.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/:</p>	
<p>Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.7.хууль тогтоомж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас энэ хуулийн 22.1-д заасан асуудлаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах; Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.8 дахь “хөрөнгө</p>	

<p>оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах”</p>
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Худалдан авах ажиллагааг оройтуулсан, ажил гүйцэтгэх боломжгүй хугацаанд гэрээ байгуулсан, Худалдан авах ажиллагааг давтан зарласан боловч оролцогч санал ирүүлээгүй</p>
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй байх, төсөл арга хэмжээний үр нөлөө буурах, чанаргүй хийгдэх.</p>
<p>Шийдвэр:Төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн, үр ашигт тавих хяналтыг сайжруулах, худалдан авах ажиллагааг журмын дагуу түргэн шуурхай зохион байгуулах зөвлөмж хүргүүлэх</p>

<p><u>Илэрсэн асуудал 9</u></p>	<p>Байгууллагын урсгал болон хөрөнгийн зардалд тусган хэрэгжүүлэх боломжтой байрны засвар, спорт цогцолборын засвар, түр хамгаалах байрны тоног төхөөрөмж худалдан авах арга хэмжээг төлөвлөж зарцуулсан байна.</p>
<p><u>Асуудлын ангилал</u></p>	<p>Нөлөө дунд</p>
<p>Бодит байдал: ОНХО-ын төсөл арга хэмжээний Их засварын зардалд байгууллагын урсгал үндсэн үйл ажиллагааны урсгал болон хөрөнгийн зардлаар санхүүжих боломжтой 5 давхрын 1 давхрын 3 өрөө байрны засвар, Спорт цогцолборын засварын 50,000 мянган төгрөгийн 3 төсөл арга хэмжээний зардлуудыг баталсан бол Шинээр хэрэгжих төсөл арга хэмжээнд байгууллагын үндсэн үйл ажиллагааны хөрөнгийн зардалд тусгах боломжтой түр хамгаалах байрны тоног төхөөрөмжийн зардалд 10,000 мянган төгрөг, ОНХО-ын их засварын зардалд тусгах Ерөө сумаас Хүдэр сумын зааг хүртэлх зам нөхөх, Бугант Захирагчийн албаны байрны өргөтгөлийн засварын 693,985.1 мянган төгрөгийн зардлуудыг тусгаж хэрэгжүүлсэн байна.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24."төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг”, 22 дугаар зүйлийн 22.1.Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана”,</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Төсвийн төслийг боловсруулах журам, аргачлалыг мөрдөөгүй, албан хаагчдын мэдлэг чадвар дутмагаас үндэслэлтэй бодитоор төлөвлөөгүйгээс хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний ангиллыг буруу төлөвлөж хэрэгжүүлсэн байна.</p>	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:Төсвийн хөрөнгө оруулалтын шалгуур хангахгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээр төсвийн хөрөнгийн үр ашиг, үр нөлөө буурах.</p>	
<p>Шийдвэр: Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг бодитоор төлөвлөж төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх. Байгууллагын урсгал болон хөрөнгийн зардлаар хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээг хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд тусгахгүй байх албан шаардлага хүргүүлэх</p>	

5.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Ерөө сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу дотоод аудитыг хийж гүйцэтгэхэд илэрсэн алдаа зөрчлийг үндэслэн “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг өгч байна.

Байгууллага өөрийн зорилгодоо хүрэхийн тулд эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэн, дотоод хяналтыг үр нөлөөг сайжруулах тогтолцоог бий болгож шийдвэр гаргалтад түүний үр дүнтэй ашиглаж хэвших шаардлагатай байна..

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Сайжруулах шаардлагатай	Засаглал эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь “эхлэлийн буюу 2-р түвшин”-д байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн асуудлуудын 50 хувь нь “нөлөө ихтэй” гэж үзсэн.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:
ДОТООД АУДИТОР



Х.БАТБААТАР

ТАЙЛАН ХЯНАСАН:
АЛБАНЫ ДАРГА

Т.ОДСҮРЭН

ТАНИЛЦСАН:

ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ ДАРГА

Б.СЭРГЭЛЭН

ТӨСВИЙН ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ

А.ТӨГСЖАРГАЛ